

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК

БАТЛАВ:

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЛЖИННЯМ

Огноо: 2020-06-30

**“ХӨРӨНГИЙН БОЛОН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ”
ҮЗҮҮЛЭХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: *ДҮТ-2020-04-34*
.....

Тендер
шалгаруулалт
дугаар: *ДҮТ/202004034*
.....

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ДҮТ/20200434** дугаар бүхий **“ХӨРӨНГИЙН БОЛОН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ” ҮЗҮҮЛЭХ КОМПАНИ СОНГОН ШАЛГАРУУЛАХ** тендерийг гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын эзлэхүүн, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 07-р сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Холбогдох мэдээллийг

Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө,

Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн

5-р давхар, 513 тоот /Утас:70041371-263, Факс:70043467,

и-мэйл хаяг: solongo.b@ndc.energy.mn хаягаар авна уу.

Тендерийг 2020 оны 07-р сарын 29 -ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Тендерийн зарын хугацаанд www.tender.gov.mn цахим хуудасны урилгын “тодруулга” хэсгийг байнга шалгана уу!

Веб хуудас: www.ndc.energy.mn

Та бүхнийг бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:
 - **Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан/**
 - **Даатгалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /баталгаажуулсан/**
 - **Компанийн дэлгэрэнгүй танилцуулга**
 - **Татварын тодорхойлолт**
 - **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт /өр төлбөртэй эсэх талаар/**
 - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгаж шаардлагатай
2. **Тендерийн иж бүрдэл**
 - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Даатгалын үйлчилгээ үзүүлэх хувь хэмжээ;
 - **Хураамжийн хувь хэмжээ**
 - **Нөхөн төлбөр олгох, олгохгүй нөхцөл**
 - **Давхар даатгалын хамгаалалтын нөхцөл**
 - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг. Үүнд:
 - Санхүүгийн тайлан - сүүлийн 3 жил /2017, 2018, 2019 он/-ийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан. Сангийн яамны цахим системд бүртгүүлсэн байх.
 - Хураамжийн орлого сүүлийн 3 жилийн аль нэгэнд 4 тэрбум ₮ өөс доошгүй байх
 - Байгууллагын нийт хөрөнгө сүүлийн 3 жил /2017, 2018, 2019 он/ 8 тэрбум ₮-өөс багагүй байх.
 - Нөөц сан 3 тэрбум ₮-өөс доошгүй байх. /Санхүүгийн зохицуулах хорооны албан тоотоор баталгаажуулж ирүүлэх/
 - Сүүлийн 3 жилийн аль нэг жил /2017, 2018, 2019 он/ ашигтай ажилласан байх
 - Даатгагдсан хөрөнгийн хохирлын нөхөн олговрыг түргэн шуурхай олгох, түргэн шуурхай олгоогүйгээс үүсэх хохирлыг бүрэн хүлээх тухай баталсан албан бичиг
 - Санхүүгийн зохицуулах хорооноос 2018, 2019 онуудад аливаа шийтгэл, арга хэмжээ авагдаагүй байх. /СЗХ-ны албан тоотоор баталгаажуулж ирүүлэх/
 - 2018, 2019 онуудад хийсэн ижил төстэй ажлуудын жагсаалт, гэрээний хуулбар, акт
 - Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
3. **Тендерийн үнэ**
 - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал

болгож болно.

- 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш гэрээ байгуулах хүртэлх хугацаанд хүчинтэй байна.
- 5. Алдааг залруулах**
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үйл ажиллагааны үнийн нилбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нилбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна

Гурав . ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Дөрөв . ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. Баталгаат засвар (ГЕН-5) 4.1. **Ажил эхлэх өдөр:**
-Мэдээлэл технологийн тоног төхөөрөмжүүдийн даатгал 2020-12-27
-Тээврийн хэрэгслийн даатгал 2020-08-20
-Реле хамгаалалтын лабораторийн үйл ажиллагааны хариуцлага болон тооног төхөөрөмжийн эрсдлийн даатгал 2020-08-20
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулснаас хойш 1 жил
4. Төлбөр (ГЕН – 7) 6.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээ баталгаажсанаас хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

Даатгагч нь хохирлын үнэлгээг тогтоохдоо даатгуулагчийн гаргасан техникийн гэмтлийн актыг үндэслэх ба хэрэв шаарлагатай бол үнэлгээ хийх эрх бүхий байгууллагаар хийлгэж болно. Үнэлгээ хийх түүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч бүрэн хариуцна.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ 8.1. Алданги оногдуулах хувь: **0.05%**
Алдангийн нийт дүн: **5%**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**Хүснэгт 1: ДҮТ ХХК-ийн 2020-2021 онд даатгалд хамрагдах
мэдээллийн технологийн тоног
төхөөрөмжүүдийн жагсаалт**

2020.03.30

Д/д	Код	Даатгалд хамруулах тоног төхөөрөмжийн нэрс	Тоо ширхэг	Үнэлгээ	Холбоо	СКАДА	Компьютер	Тоолуур
1	2030-01-011	Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж.RAD.4U.MP2100	1	19,701,670				
2	20580238	АТС TDA-200	1	25,946,627				
3	2002-10-012	Байгууламж холбооны шугам/ ДҮТ-ДЦСЗруу/	1	137,500,000				
4	2002-10-014	Байгууламж холбооны шугам /ДҮТ-406 шкаф/	1	28,710,000				
5	20580359	Мультиплексор MP2104	1	31,737,383				
6	20580350	Мультиплексор PMX-3004	1	7,930,579				
7	20580416	АТС TDA-100	1	25,946,627				
8	2004-10-351	Өндөр давтамжийн холбоо powerlink	1	63,960,548				
9	2030-01-002	COBUX	1	11,200,000				
10	2030-01-003	POSUM	1	15,500,000				
11	2030-01-004	Optical laser X1.2 LC SFP, 1550nm	1	12,000,000				
12	2030-01-005	STM-1 access unit, VC12	1	22,500,000				
13	2030-01-006	Aggregate optical Unit STM1/STM4, SFP Units support	1	19,200,000				
14	2030-01-007	2 Mb/s IF (E1), 8 G.703 Interfaces 8	1	16,000,000				
15	2030-01-008	Ethernet switch, 8 ports, PoE	1	7,200,000				
16	2030-01-012	MP-2100M-ML-2E1/SC/13L module	1	9,500,000				
17	2030-01-014	MP2100M-E&M8 module	1	5,600,000				
18	2030-01-016	Медиа конвертор /FIB1-E1R-SC-20B/A/	1	900,000				
19	201020507	Диспетчерийн коммутатор	1	134,990,000				
20	2010-00-552	Нэтбүүк /i7 DELL/	1	1,989,000				
21	2004-10-508	ДДЦС-ын 48 В-ын тогтмол үүсгүүр	1	39,925,000				
22	2004-10-497	DC панель /053 - 220/110/35 кВ-ын Эрдэнэт дэд станц/	1	11,922,003				
23	2004-10-169	220В-ын тасралтгүй тэжээлийн удирдлагын систем APC	1	21,233,193				
24	20590471	Хяналтын системийн процессор	1	3,864,000				
25	20580114	Сервир компьютер- Sun Fire V240	1	60,158,371				
26	20580124	ТСИ-ийн оролтын модуль SEIMENS	1	18,546,000				
27	20580144	Инженерийн ажлын станцын процессор SunBlade 1500	1	9,173,810				
28	20580244	X-terminal Transform AX	1	44,182,754				

29	2004-10-285	RTU 560 ба стандарт кабинетийн хамт	1	29,539,265				
30	2004-10-289	Актив чадлын хувиргагч D8RW2	1	2,462,121				
31	2004-10-290	Реактив чадлын хувиргагч D8RW3	1	2,462,136				
32	2004-10-578	Аналог карт 23AE /010 - Даланзадгад ДЦС/	5	4,500,000				
33	2004-10-579	Тоон карт 23BE /010 - Даланзадгад ДЦС/	5	4,500,000				
34	2010-20-503	Шилэн кабелийн WAN сүлжээний төхөөрөмж/MOXA-EDS508A/	1	6,751,875				
35	20590479	Cisco 3750 catalyst router төхөөрөмж	1	19,624,881				
36	2010-20-506	Cisco 3925 сүлжээний төхөөрөмж	1	18,810,000				
37	2010-20-514	Dell R 720 Сервер	1	11,990,000				
38	2070-02-003	Сервер компьютер	1	27,700,000				
39	2070-02-005	Сүлжээний төхөөрөмж	1	10,081,200				
40	2010-00-478	Нөөтбүүк	1	1,989,000				
		ДҮН		935,357,843				

Даатгалд хамаарагдах хөрөнгө нь байршлаас үл хамааран “Диспетчерийн Үндэсний Төв” ХХК-ийн тэнцлийн бүртгэлд хамаарагдах хүснэгт №1-д зааснаар тодорхойлогдсон болно.

Хүснэгт 2: РЕЛЕ ХАМГААЛАЛТЫН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИУЦЛАГА БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЭРСДЛИЙН ДААТГАЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго

Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага MNS ISO/IEC 17020:2013 стандартын 5.4 заалтын дагуу Реле хамгаалалтын лабораторийн тоног төхөөрөмж, үйл ажиллагаанаас үүдэн гарах эрсдлийн зардлыг даатгалаар нөөцийн сан бүрдүүлж шийдвэрлэнэ.

2. Даатгалын зориулалт

2.1. Тоног төхөөрөмжийн даатгал

/ төгрөгөөр/

№	Даатгалын төрөл	Хөрөнгийн дүн	Тайлбар
1	OMICRON CMC 356 /РХА-ын байгууламж шалгах багаж/	79,970,000	
2	OMICRON CPC 100 /ЦДАШ эсэргүүцэл хэмжих багаж К коэффициент хэмжих модуль/	131,500,000	
3	Power Quality Analyzer /2-гч хзохээний гүйдэл хүчдэл, характеристик шалгах багаж/	18,920,000	
4	hipot slaughter /Реле хамгаалалт шалгах туршилтын төхөөрөмж HIPOT-02975/	6,000,000	
	Нийт дүн	236,390,000	

2.2. Хариуцлагын даатгал

/Төгрөгөөр/

№	Зориулалт	Хөрөнгийн үнэлгээ	Даатгалын хураамж (хувь)	Жилийн дүн	Тайлбар
1	Үйл ажиллагааны хариуцлагын даатгал	100,000,000	1	1,000,000	

3. Тавигдах шаардлага

3.1. Тоног төхөөрөмжийн даатгалд үндсэн үнийн дүнг үндэслэж нөхөн олговрыг тооцно.

3.2. Тоног төхөөрөмжийн даатгалын гэрээний хугацааг өмнөх даатгалын хугацаа дуусгавар болсоны дараа шинээр хугацааг сунгаж байгуулна.

3.3. Нөхөн олговрыг даатгуулагч компанийн гэмтлийн актыг үндэслэн эсвэл үйлдвэрлэгч компанийн үнийн санал түүнтэй дүйцэхүйц дүнгээр тооцож нөхөн олговор олгоно.

3.4. Нөхөн олговрыг гэмтлийн акт гарснаас хойш ажлын 5 хоногт буцаан олгоно.

Хүснэгт 3: Тээврийн хэрэгслийн даатгалын ажлын даалгавар

№	Даатгалын нөхцөл	Үзүүлэлт
1	Даатгуулах автомашины тоо	5
2	Даатгуулах хугацаа	1 жил
3	Авто машины даатгал	Иж бүрэн даатгал

№	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн улс, он	Ашигласан орсон он	Арлын дугаар	Моторын дугаар	Анхны өртөг
1	Хьюндай Соната-LF	01-06 УБҮ	Солонгос, 2014	2015	КМНН241СА FA049192	2000	49,900,000
2	Chevrolet colorado	01-93 УНӨ	2014	2016	МММ148FLO ЕН633428	2500	64,500,000
3	Ланд круйзер 200	33-99 УНБ	2018	2018	SN1AN08W7 6C504613	4608	228,000,000
4	Хьюндай Старекс	63-12 УНП	2016	2017	РАНУ87706 3	2359	74,500,000
	Ланд круйзер200						157,000,000
Нийт							573,900,000

Даатгуулах хугацаа-1 жил

Даатгалын хураамж Даатгалын үнэлгээний-1.4%-иас доош

Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

"ДҮТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа

1. Бид, "Хөрөнгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулах" тендер (Төслийн дугаар **ДҮТ-2020-04-34**, Бүртгэлийн дугаар **ДҮТ/202004034**)-ийг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ	БАТЛАВ.	ГҮЙЦЭТГЭГЧ
_____	_____	_____
(Тамга, тэмдэг)		(Тамга, тэмдэг)
_____	_____	_____
(Гарын үсэг)		(Гарын үсэг)
_____	_____	_____
(Албан тушаал)		(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний
дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :
Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.
4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл; Техникийн тодорхойлолт;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]